

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/05/НА-СТА-ТӨА

ШШГЕГ-ЫН ХАРЬЯА “ШТН” ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2020 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
3.6 Үйлдвэрлэлийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ШТН	Шохой тоосго нүүрс
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

1. Аудитын санал дүгнэлт



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.03.15 № 01/214
танай _____-ны № _____-т

"ШТН" ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Я.МАРТХҮҮ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "ШТН" ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"ШТН" ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Бид санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулах үзэл баримтлалын хамрах хүрээ нь зөвхөн санхүүгийн тайлангуудыг авч үзсэн. Үүнээс болоод суурь үзэл баримтлалынх нь хамрах хүрээ илүү өргөн болсон. Энэхүү санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөгөөр тайлант онд 20.4 мянган тн 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 781,600.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, 115,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 5.9 мянган тн 6 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 311,486.83 /НӨАТ орсон дүн/ мянган төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 28,9 хувь, борлуулалтын төлөвлөгөө 39,9 хувьтай байна. Энэ нь Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотой хөл хорио тогтоож улсын хил хаасантай холбоотой үйлдвэрлэлд шаардлагатай материалыг импортлох боломжгүй болсноос үйлдвэрлэлийн болон борлуулалтын төлөвлөгөө тасалдсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

D 2022/2022 он /ALBAN PSHIE
19020560

Бусад асуудал

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайланд онд 2021 онд 497,264.5 мянган төгрөгийн орлоготой, 272,393.8 мянган төгрөгийн зардал, 25,000.0 мянган төгрөгийг ШШГЕГ төвлөрүүлж, 199,870.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Балансын зүйл	Үлдэгдэл	
	1 сарын 1	12 сарын 31
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгө	52,213.93	431,689.19
Дансны авлага	11,410,700.00	11,410,700.00
Бусад авлага	59,744,590.68	24,751,572.68
Бараа материал	191,520,987.70	262,092,457.72
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	73,540,000.00	71,740,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	336,268,492.31	370,426,419.59
Үндсэн хөрөнгө	614,974,254.07	720,727,494.08
Биет бус хөрөнгө	692,404,000.00	692,404,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,307,378,254.07	1,413,131,494.08
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,643,646,746.38	1,783,557,913.67
Дансны өглөг	31,480,913.90	78,667,460.90
Цалингийн өглөг	124,625.42	0.00
Татварын өр	18,398,500.40	15,974,015.13
НДШ - ийн өглөг	154,229.06	484,559.88
Урьдчилж орсон орлого	6,028,000.00	6,028,000.00
Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	6,602,050.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	56,186,268.78	107,756,085.91
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	56,186,268.78	107,756,085.91
Өмч: - төрийн	1,156,313,966.01	1,156,313,966.01
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	181,724,011.25	181,724,011.25
Хуримтлагдсан ашиг	249,422,500.34	337,763,850.50
Тайлангийн үеийн ашиг	0.00	199,870,713.78
Өмнөх үеийн ашиг	249,422,500.34	137,893,136.72
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,587,460,477.60	1,675,801,827.76
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,643,646,746.38	1,783,557,913.67

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО(цэвэр)	448,848,916.08	497,264,468.01
БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	291,710,420.09	180,285,328.24
НИЙТ АШИГ (алдагдал)	157,138,495.99	316,979,139.77
Түрээсийн орлого	0.00	0.00
Хүүний орлого	109,017.49	0.00
Ногдол ашгийн орлого	0.00	0.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	0.00	0.00
<u>ОРЛОГЫН ДҮН	109,017.49	0.00
Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
Ерөнхий ба удирдлагын зардал	116,151,092.18	90,879,879.47
Санхүүгийн зардал	0.00	0.00
Төвлөрүүлсэн	0.00	25,000,000.00
ЗАРДЛЫН ДҮН	116,151,092.18	115,879,879.47
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
Бусад ашиг (алдагдал)	281,628,800.00	201,099,260.30
ОЛЗ,ГАРЗЫН ДҮН	281,628,800.00	201,099,260.30
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ(алдагдал)	322,725,221.30	201,099,260.30
Орлогын татварын зардал	4,117,782.13	1,228,546.52
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (алдагдал)	318,607,439.17	199,870,713.78
Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (алдагдал)	318,607,439.17	199,870,713.78

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	-69,184,938.83	1,268,853,038.43
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны эсрэг	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	318,607,439.17	318,607,439.17
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
2020 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	249,422,500.34	1,587,460,477.60
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны эсрэг	0.00	0.00	-111,529,363.62	-111,529,363.62
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	199,870,713.78	199,870,713.78
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
2021 оын 12 сарын 31-р үлдэгдэл	1,156,313,966.01	181,724,011.25	337,763,850.50	1,675,801,827.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
<u>МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	346,667,035.00	331,237,625.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	346,667,035.00	329,279,825.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
Буцаан авсан албан татвар	0.00	0.00
Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
Бусад мөнгөн орлого	0.00	1,957,800.00
<u>МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	351,091,558.94	533,222,461.74
Ажиллагчдад төлсөн	156,809,788.96	133,488,227.87
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,979,519.03	2,629,790.89
Бараа материал худалдан авахад төлсөн	96,164,470.20	48,223,370.83
Ашиглалтын зардалд төлсөн	24,231,174.00	26,799,957.15
Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	44,819,930.00	57,158,855.00
Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
Татварын байгууллагад төлсөн	15,944,117.35	56,339,347.00
Даатгалын төлбөрт төлсөн	418,837.00	285,525.00
Бусад мөнгөн зарлага	8,723,722.40	208,297,388.00
<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-4,424,523.94	-201,984,836.74
<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
<u>МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	109,017.49	0.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлө	0.00	0.00
Хүлээн авсан хүүний орлого	109,017.49	0.00
Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР	109,017.49	0.00
<u>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
<u>МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	0.00	227,364,312.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээ	0.00	0.00
Төрөл бүрийн хандив	0.00	0.00
Бусад	0.00	227,364,312.00
<u>МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	30,000,000.00	25,000,000.00
Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
Бусад	30,000,000.00	25,000,000.00
<u>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-30,000,000.00	202,364,312.00
<u>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-34,315,506.45	379,475.26
<u>МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛД	34,367,720.38	52,213.93
<u>МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛД	52,213.93	431,689.19

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “ШТН” ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийн элэгдлийг ашигласан хугацааны туршид байгуулах, НББ-ийг аккурал сууриар хөтлөх, бэлэн бүтээгдэхүүний бүртгэл, ББӨ-ийн тооцооллыг үнэн зөв гүйцэтгэх, бараа материалын орлого зарлагын хөдөлгөөнийг тухай бүртгэж, тайлагнаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ нь хорих ял эдэлж буй хоригдлыг ажлын байраар хангах, гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх “Эрдэнэт” УБҮ-ыг /тухайн үеийн нэршлээр/ боловсруулсан шохойгоор хангах зорилгоор Хорих 415-р анги ашиглаж ирсэн бөгөөд “Шохой тоосгоны нэгдэл” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар үүсгэн байгуулагдсан үеэс дангаараа шохойн чулуу, шохой, эрдэс нунтаг, замаскны бэлдэц, мозайкан чулуу боловсруулан үйлдвэрлэж, 2020 оноос БНХАУ-ын технологиор барилгын ажилд хэрэглэх 3 төрлийн хуурай хольцыг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, үйл ажиллагааг явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын хариуцсан ажилтан буюу ажлын нэгж байхгүй төлөвлөгөө хуваарийг батлуулаагүй байна.

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг

аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“ШТН” ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 497,264.5 мянган төгрөгийн 1,5 хувиар буюу 6,732.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,049.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 497,264.5 мянган төгрөгийн 1,5 хувиар буюу 7,458.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,594.2 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 726.2 мянган төгрөгөөр өссөн байна.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ нь хорих ял эдэлж буй хоригдлыг ажлын байраар хангах, гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх “Эрдэнэт” УБҮ-ыг /тухайн үеийн нэршлээр/ боловсруулсан шохойгоор хангах зорилгоор Хорих 415-р анги ашиглаж ирсэн бөгөөд “Шохой тоосгоны нэгдэл” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар үүсгэн байгуулагдсан үеэс дангаараа шохойн чулуу, шохой, эрдэс нунтаг, замаскны бэлдэц, мозайкан чулуу боловсруулан үйлдвэрлэж, 2020 оноос БНХАУ-ын технологиор барилгын ажилд хэрэглэх 3 төрлийн хуурай хольцыг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, үйл ажиллагааг явуулж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“ШТН” ТӨААТҮГ нь 1963 онд шохойн чулууг боловсруулж барилгын шохой, асфальтбетоны нэмэлт эрдэс нунтаг, мозайкн шалны дүүргэгч, замаскны бэлдэц үйлдвэрлэх зориулготой байгуулагдсан ШШГЕГ-ын харьяа байгууллага юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ”, Компанийн тухай хуулийн 3.1-т “Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, 16.2-т “Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана” гэж заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц оновчтой, чиг үүргийн давхардал үүсээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“ШТН” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	52.21	431.69	379.48
Авлага	71,155.29	36,162.27	(34,993.02)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	73,540.00	71,740.00	(1,800.00)
Бараа материал	191,520.99	262,092.46	70,571.47
Үндсэн хөрөнгө	1,307,378.25	1,413,131.49	105,753.24
Нийт хөрөнгө	1,643,646.75	1,783,557.91	139,911.17
Өр төлбөр	56,186.27	107,756.09	51,569.82
Засгийн газрын оролцоо	1,587,460.48	1,675,801.83	88,341.35
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,643,646.75	1,783,557.91	139,911.17

2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгө 431.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэлд Маргад энержи ХХК 8,250.0 мянган төгрөг, Тулах Соёмбо Констракшн ХХК 7,563.3 мянган төгрөг, Мон Гипс ХХК 6,430.0 мянган төгрөг, Хөнгөн бетон ХХК 7,326.0 мянган төгрөгийн авлага нийт авлагын 81,7 хувийг эзэлж байна. Бараа

материалын дансны үлдэгдэл 262,092.46 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 70,571.5 мянган төгрөгөөр өссөн нь шохойн чулууны дуусаагүй 136,320.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,413,131.5 мянган төгрөг болж 105,753.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 146,906.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн эцсийн үлдэгдэл 1,675,801.8 мянган төгрөг болж 88,314.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Үйлдвэрлэлийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үйлдвэрлэлийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Бүтээгдэхүүний төрөл	Үйлдвэрлэлийн			Борлуулалтын		
	Төлөвлөгөө	Биелэлт	хувь	Төлөвлөгөө	Биелэлт	хувь
Шохой	1300		-	162,500.0		-
Шохойн чулуу	15000	-	-	292,500.0	17,944.9	6.1
Мозайкан чулуу	2000	3,318.0	165.9	25,000.0	23,166.7	92.7
Эрдэс нунтаг	500	363.6	72.7	40,000.0	24,440.0	61.1
Замаск бэлдэц	1000	1,878.3	187.8	90,000.0	149,221.2	165.8
Хар замаск	370	168.7	45.6	103,600.0	47,438.7	45.8
Цагаан замаск	170	141.8	83.4	44,200.0	38,440.6	87.0
Плитаны цавуу	85	37.9	44.6	23,800.0	10,834.7	45.5
Нийт дүн	20425	5,908.26	28.9	781,600.0	311,486.83	39.9

Тайлант онд 20.4 мянган тн 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 781,600.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, 115,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 5.9 мянган тн 6 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 311,486.83 /НӨАТ орсон дүн/ мянган төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 28,9 хувь, борлуулалтын төлөвлөгөө 39,9 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 180,285.3 мянган төгрөг буюу 63,7 хувь нь борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртөг, 90,879.9 мянган төгрөг буюу 32,1 хувь удирдлагын зардал эзэлж байна

4.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “ШТН” ТӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Үйлдвэрлэлийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Бүтээгдэхүүний төрөл	Үйлдвэрлэлийн			Борлуулалтын		
	Төлөвлөгөө	Биелэлт	хувь	Төлөвлөгөө	Биелэлт	хувь
Шохой	1300		-	162,500.0		-
Шохойн чулуу	15000	-	-	292,500.0	17,944.9	6.1
Мозайкан чулуу	2000	3,318.0	165.9	25,000.0	23,166.7	92.7
Эрдэс нунтаг	500	363.6	72.7	40,000.0	24,440.0	61.1
Замаск бэлдэц	1000	1,878.3	187.8	90,000.0	149,221.2	165.8
Хар замаск	370	168.7	45.6	103,600.0	47,438.7	45.8
Цагаан замаск	170	141.8	83.4	44,200.0	38,440.6	87.0
Плитаны цавуу	85	37.9	44.6	23,800.0	10,834.7	45.5
Нийт дүн	20425	5,908.26	28.9	781,600.0	311,486.83	39.9

Тайлант онд 20.4 мянган тн 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 781,600.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, 115,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 5.9 мянган тн 6 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 311,486.83 /НӨАТ орсон дүн/ мянган төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт 28,9 хувь, борлуулалтын төлөвлөгөө 39,9 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 180,285.3 мянган төгрөг буюу 63,7 хувь нь борлуулсан бүтээгдэхүүний өөрийн өртөг, 90,879.9 мянган төгрөг буюу 32,1 хувь удирдлагын зардал эзэлж байна

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан төлөвтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №1/24 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	2	604,999.7	1	448,848.6	1	156,151.1	25.8
Зөвлөмж	1	22,148.6	1	22,148.6	-	-	-
Нийт дүн	3	627,148.3	2	470,997.2	1	156,151.1	25.8

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт 75,2 хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд үйлдвэрлэлийн төлөвлөгөө биелүүлж ажиллах албан шаардлага хэрэгжээгүй байна. Энэ нь нь Ковид-19 цар тахлын улмаас Монгол улсын хил хааж ачаа тээврийн үйлчилгээ саатсанаас үйлдвэрийн түүхий эд тасалдсантай холбоотой байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,030,717.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,030,717.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

8.1 Залруулсан алдаа

4.1.1 Санхүү тайланг санхүүгийн программын алдаанаас шалтгаалан 1,030,717.6 мянган төгрөгийн зөрүүтэй татагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” гэсэн заалтыг үндэслэн залруулга хийсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс			
				Залруулга		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	ШШГЕГ-ын харьяа “ШТН” ТӨААТҮГ	1	1,030,717.6	1	1,030,717.6		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn